# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт--гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.** /"Алсын хараа-2050" зорилт 5.3, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/ | | | | | | | |
| **Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.** | | | | | | | |
| 1.1. | Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлж, бусад байгуулллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах. | - | Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо | 12655 | 13000 | 2024 оны хагас жилийн байдлаар нийт 4825 иргэнд тоон гарын үсэг олгосон. | 37,1% |
| | | | Тоон гарын үсэг олгох бусад байгууллагын цахим /киоск/ машины тоо | 0 | 2 | Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, сумын Хаан банкны тооцооны төвүүдэд 9 киоск машинаар тоон гарын үсэг олгож байна. | 50% |
| 1.2. | Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх. | 27 сая | Өмнөговь аймгийн сумдад шинээр байршуулсан Улсын бүртгэлийн Киоск машины тоо | 0 | 1 | - Өмнөговь аймгийн Засаг даргын "Нутгийн хишиг" мөрийн хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 02 дугаар сарын 21 ны өдөр Цогтцэций сумын Засаг даргын тамгын газар Улсын бүртгэлийн 1 киоск машиныг байршуулан, хэвийн ажиллагаанд оруулсан.<br>- 2024 оны 04 дүгээр сарын 29 ны өдөр Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт Улсын бүртгэлийн 1 киоск машиныг байршуулан, хэвийн ажиллагаанд оруулсан.<br>- УБЕГ, Өмнөговь аймгийн ЗДТГазартай хамтран Ханбогд сумын Цагаан хад суурьшлын бүсэд "Гадаад паспорт захиалах автомат машин"-ыг байршуулж 33 иргэний гадаад паспортын захиалгыг авсан. | 100% |
| | | - | Улсын бүртгэлийн Киоск машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо | 7320 | 10000 | Улсын бүртэлийн лавлагаа- 3016<br>Иргэний тоон гарын үсэг олгох үйлчилгээ -816<br>Цахим гадаад паспортын захиалга - 62<br>Улсын бүртгэлийн төлбөр төлөх үйлчилгээ - 743<br>Нийт 4637 улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. | 63.3% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3. | Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх. | - | Улсын бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо | 0 | 1 | Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ 2024 оны 4 улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд судалгаа хийгдэж байна. | 50% |
| 1.4. | Улсын бүртгэлийн хууль, журам, ажил, үйлчилгээг сурталчлах. | - | Өмнөговь Улсын бүртгэлийн хэлтсийн вэйб сайтад шинэ мэдээ, мэдээлэл байршуулсан тоо | 18 | 30 | МУИХурлын сонгуультай холбоотой иргэдийн шилжилт хөдөлгөөний анхаарах асуудал болон цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр Улсын бүртгэлийн хэлтсийн вэйб сайтад нийт 49 удаа байршуулсан. | 100% |
| | | - | Аймгийн ЗДТГазрын ОНХА, Алтан говь, Мэлмий телевизээр мэдээлэл түгээсэн тоо | 8 | 12 | Даланзадгад суманд шинээр байгуулагдсан 9,10 дугаар багийн шилжилт хөдөлгөөн, МУИХурлын сонгуулийн талаар, "Шинэ хоршоо хөдөлгөөн" зэрэг цаг үеийн мэдээллийг<br>Говийн наран телевиз – 3,<br>ОНХА – 1 ,<br>Даланзадгад хот – 1,<br>Ханбогд.мн сайтаар – 2 нийт 7 удаа мэдээлэл хүргэсэн. | 58,3% |
| 1.5. | Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль, журмуудыг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх. | - | Бэлтгэж түгээсэн контентын тоо | 0 | 4 | Улсын бүртгэлийн хэлтсийн вэйб сайтад улсын бүртгэлийн тухай хууль, МУИХурлын сонгуулийн тухай хуультай холбоотой зөрчлөөс урьдчилан сэргийлэх контентыг 3 удаа түгээсэн. | 75% |
| **Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 2.1. | Улсын бүртгэлийн үйлчилгээг хууль, журмын хүрээнд үнэн зөв, шуурхай хүргэх. | - | ИУБүртгэлийн үйлчилгээний тоо | 26482 | 26500 | Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр давхардсан тоогоор 14536 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. | 50% |
| | | | ЭХЭУБүртгэлийн үйлчилгээний тоо | 12425 | 12500 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 6527 хүсэлтийг хүлээн авч, цахимжуулан бүртгэж, мэдээллийн санд баталгаажуулсан. | 50% |
| | | | ХЭУБүртгэлийн үйлчилгээний тоо | 3700 | 3750 | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1551 хүсэлтийг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэн, архивт шилжүүлсэн. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2. | Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системийг ашиглах. | - | “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулсан нотариатчидын тоо | 0 | 3 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 3 нотариатчидтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 50% |
| | | | Нотариатчаар зуучлуулан бүртгэсэн бүртгэлийн тоо | 0 | 30 | Нотариатчаар зуучлуулсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хүсэлт ирээгүй. | 50% |
| 2.3. | Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийн хэрэглээ, цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх. | - | Цахимаар бүртгүүлэхээр системд холбогдсон банк, санхүүгийн байгууллагын тоо | 0 | 1 | Цахимаар бүртгүүлэхээр системд холбогдсон банк, санхүүгийн байгууллага судлаж байна. | 50% |
| | | | Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо | 0 | 10 | Барьцааны гэрээг цахимаар бүртгэх хүсэлт ирээгүй. | 50% |
| | | | Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо | 0 | 12 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд ирүүлсэн 26 онлайн мэдүүлгийг хүлээн авснаас 23 барьцааны гэрээг дуусгавар болгож, 3 хүсэлтийг татгалзаж шийдвэрлэсэн. | 100% |
| 2.4. | Улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. | - | Улсын бүртгэлийн 24/7 Киоск машины тоо | 0 | 1 | 2024 оны 02 сарын 01 ний өдрөөс Улсын бүртгэлийн хэлтсийн байранд 24/7 киоск машин 1 ажиллаж байна. | 100% |
| | | Аймгийн ЗДТГазрын санхүүжилт | “Явуулын оффис”- Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ” зохион байгуулсан тоо | 16 | 20 | Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд “Явуулын оффис”–оор улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.<br>- 2024 оны 01 дүгээр сарын 20 ны өдөр Даланзадгад суманд шинээр байгуулагдсан “Чандмань” 9 дүгээр багийн 244 иргэнд,<br>- 2024 оны 01 дүгээр сарын 21 ны өдөр Даланзадгад суманд шинээр байгуулагдсан “Начин” 10 дугаар багийн 204 иргэнд,<br>- 2024 оны 01 дүгээр сарын 23-25 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Сэврэй суманд 89 иргэнд,<br>- 2024 оны 01 дүгээр сарын 22 ны өдөр Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүсэд 226 иргэнд, | 75% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 2024 оны 02 дугаар сарын 22 ны өдөр Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүсэд 106 иргэнд,<br>- 2024 оны 02 дугаар сарын 24 ны өдөр Даланзадгад суманд шинээр байгуулагдсан "Чандмань" 9 дүгээр багийн 154 иргэдэд,<br>- 2024 оны 02 дугаар сарын 25 ны өдөр Даланзадгад суманд шинээр байгуулагдсан "Начин" 10 дугаар багийн 87 иргэдэд,<br>- 2024 оны 03 дугаар сарын 02 ны өдөр Даланзадгад суманд шинээр байгуулагдсан "Чандмань" 9 дүгээр багийн 106 иргэдэд,<br>- 2024 оны 03 дугаар сарын 03 ны өдөр Даланзадгад суманд шинээр байгуулагдсан "Начин" 10 дугаар багийн 63 иргэдэд,<br>- 2024 оны 03 дугаар сарын 22 ны өдөр Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүсэд 146 иргэнд,<br>- 2024 оны 04 дүгээр сарын 01,02 ны өдрүүдэд Хүрмэн суманд 156 иргэнд,<br>- 2024 оны 04 дүгээр сарын 15-18 ны өдрүүдэд Гурвантэс, Ноён, Сэврэй сумдад 407 иргэнд,<br>- 2024 оны 04 дүгээр сарын 27 ны өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГазраас зохион байгуулсан төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх "Хөдөлгөөнт баг" арга хэмжээнд оролцож 290 гаруй иргэнд,<br>- 2024 оны 05 дугаар сарын 01 ний өдөр Өмнөговь аймгийн Ханхонгор суманд 58 иргэнд,<br>- 2024 оны 05 дугаар сарын 30 ны өдөр Цогтцэций суманд Улсын бүртгэлийн "Явуулын оффис"-оор 190 иргэнд тус тус улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>Нийт 15 удаа. | |
| 2.5. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар Улсын | - | E-business порталаар бүртгэсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоо | 777 | 800 | ХЭУБүртгэлтэй холбоотой E-Bussines цахим системээр нийт 435 хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хуулийн этгээдийн 76 нэрийг баталгаажуулж, 9 хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулж 350 хүсэлтийг бүртгэхээс татгалзсан. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх. | | E-mongolia порталаар бүртгэсэн иргэний улсын бүртгэлийн тоо | 298 | 320 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia цахим системээр Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 29 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Гадаад паспорт захиалах 31, иргэний үнэмлэх дахин захиалах 22 хүсэлтийн дагуу хэвлэгдэн ирсэн бичиг баримтыг иргэдэд түргэн шуурхай олгож нийт 82 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. | 50% |
| 2.6. | Иргэний үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох технологи /NFC/-ийг нэвтрүүлэх. | - | /NFC/-ийг нэвтэрсэн тохиолдолд иргэний үнэмлэхний чипэнд бичилт хийсэн тоо | 0 | 200 | Иргэний үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох технологи /NFC/-ийг УБЕГазраас нэвтрүүлэх ажил 2024 оны 4 дүгээр улиралд хийгдэхээр төлөвлөгдсөн. | 50% |
| 2.7. | Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулах. | - | Тодорхойгүй төлөвт байгаа иргэний эх нотлох баримтын мэдээлэл, судалгааг УБНАрхивт хүргүүлсэн тоо | 0 | 1 | 2024 оны 05 дугаар сарын 21 ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Нэгдсэн архивт иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 2700 иргэний судалгааг хүргүүлсэн. | 100% |
| **Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг хангаж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1. | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах. | - | Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь. | 100% | 100% | Хяналтын улсын байцаагч Төлөвлөгөөт шалгалт 24, Гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт 21, өргөдөл 43 нийт 88 удаагийн хяналт шалгалтаар шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр материалын 2266 бүртгэлд, хуулийн этгээдийн шинээр үүсгэн байгуулагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон 268 бүртгэлийн бүрдүүлбэр материалд, газар өмчлөх эрхийн бүртгэл, барьцаат зээлийн гэрээ, БЗГэрээ дуусгавар болгосон, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн 822 бүртгэлийн бүрдүүлбэр материалд, нийт 3356 бүртгэлд хяналт шалгалт хийж, иргэний бүртгэлийн чиглэлээр 10, хуулийн этгээдийн бүртгэлээр 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 31 нийт 43 дүгнэлтийг үйлдэж Хяналт шалгалтын газарт хүргүүлж, зөрчлийг бүрэн шийдвэрлэсэн. | 50% |
| 3.2. | Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийн | - | Хэлтсийн эрсдэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас | 3 | 5 | Хэлтсийн эрсдэлийн төлөвлөгөөнд тусгагдсан<br>- **Б1 -** Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сүлжээний хурд хэвийн болсон. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах. | | бууруулсан эрсдэлийн тоо | | | - **В2** - Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Улсын бүртгэлийн хэлтсийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах” Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын /2023111631/01/01 урилгын дугаартай 70 000 000 төгрөгийн тендир 2023 оны 11 дүгээр сарын 16 ны өдөр зарлагдсаны дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04 ны өдрийн А/2288 захирамжаар “Саус гоби компьютерс” ХХКомпанийн нийлүүлсэн 11 нэр төрлийн 29 ширхэг 68,704,900 (Жаран найман сая долоон зуун дөрвөн мянга есөн зуу) төгрөгний үнэ бүхий тоног төхөөрөмжийг хүлээж авсан. | |
| 3.3. | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах. | - | Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо | 157 | 159 | 2024 оны 05 дугаар сарын 30 ний өдрийн байдлаар бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, мэдээллийг бүрэн гаргаж, Shilen.gov.mn сайтад байршуулсан.<br>Нийт 69 удаа | 50% |
| | | | Тайлагнасан мэдээллийн мөнгөн дүн | 1,163,403,420 | 1.163,403,420 | Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгний орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг бүрэн байршуулсан. | 50% |
| 3.4. | Төрийн аудитын газраас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх. | - | Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо, биелэлтийн хувь. | 100% | 100% | 2024 оны 01 дүгээр сарын 25 ны өдөр Өмнөговь аймгийн Төрийн Аудитын газраас Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланд түүврийн аудитын шалгалтад хамрагдаж зөвлөмж, албан шаардлага, акт, зөрчилгүй дүгнэгдсэн. | 100% |
| 3.5. | Тог баригч, бусад тоног төхөөрөмжийн эд ангийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх. | | Тоног төхөөрөмжүүдэд гэмтэл гарсан үед засварласан тоо | 0 | 5 | Ханбогд, Цогтцэций, Гурвантэс, Манлай сумын улсын бүртгэгч нарын тоног төхөөрөмжийг 4 удаа засварласан. | 100% |
| 3.6. | Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах. | | Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан хувь | 100% | 100% | Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тухай бүр хангаж ажилласан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 4.1. | МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг хангаж ажиллах. | | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100% | 100% | - Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Өмнөговь аймгийн 15 сумын сонгуулийн хэсэг байгуулж, нутаг дэвсгэрийг зарласан тухай тогтоолыг нягтлан шалгаж, Election.gasr.mn системд 15 сумын 61 багийн 63 хэсгийн хаягийн мэдээллийг бүрэн баталгаажуулсан.<br>- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/61 тоот тушаал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 16 ны өдрийн 3/10685 тоот зөвлөмж чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 16 ны өдрийн 1/4924 тоот зөвлөмжийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж 2024 оны 04 дүгээр сарын 26-ний өдрийн 18.00 цагт шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоож илтгэх хуудсыг ИУБГазар, ХШГазарт тус тус хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.1, 20.6.2, 20.6.3, 20.6.4, 20.6.5, 20.6.6 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад хийгдсэн нэмэлт тэмдэглэгээг нягтлан шалгаж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн. | 80% |
| 4.2. | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг хангаж ажиллах. | | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100% | 100% | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийн хүрээнд бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 50 % |
| **Зорилт 5.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 5.1. | Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх. | Төсөл, хөтөлбөр | Гадаадад туршлага судалсан, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 4 | 6 | 2024 оны 05 дугаар сарын 20-24 ний өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 11-т заасны дагуу хамт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олноо манлайлсан албан хаагчдыг дэмжих зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тогтвортой хөгжлийн хөтөч НҮТББайгууллага хамтран Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулсан "Хүртээмжтэй манлайлал" сэдэвт сургалтад Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 11 албан хаагч хамрагдсан. | |
| 5.2. | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид бүртгэх эрх авах. | | Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумын тоо | 4 | 8 | - УБЕГазрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 24 ны өдрийн Б/55 тоот тушаалаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч З.Хасар, УБЕГазрын даргын даргын 2024 оны 04 дүгээр сарын 05 ны өдрийн Б/217 тоот тушаалаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч А.Цэцэгжаргал нар шинээр томилгдон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.<br>- УБЕГазрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15 ны өдрийн Б/298 тоот тушаалаар улсын бүргэгч Б.Баясгалан, Ч.Батхүү, А.Цэрэндолгор, Ч.Агиймаа, У.Нандинцэцэг, М.Уранцэцэг, Н.Өлзийсүрэн, У.Цэенням, Б.Баттулга, Л.Мөнхцэцэг, Б.Буянжаргал нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх нээлгэн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байна.<br>- УБЕГазрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15 ны өдрийн Б/297 тоот тушаалаар улсын бүртгэгч Б.Баттулга, Н.Өлзийсүрэн нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх нээлгэн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байна. | 100% |
| **Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 6.1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх . | - | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн | 8 | 12 | АТГ-аас бэлтгэсэн "Авлигатай тэмцэх газрын мэдээлэл" нэвтрүүлэг, "110 подкаст", "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэрүүд" зэрэг мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэсэн.<br>Нийт 8 удаа. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо | | | | |
| | | | АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо | 2 | 3 | Авлигатай тэмцэх газраас "Авлигын эсрэг нэгдэе" соён гэгээрүүлэх аянд Улсын бүртгэлийн хэлтэс нэгдэж Улсын бүртгэлийн хэлтсийн байранд соён гэгээрүүлэх самбарыг бэлтгэн байршуулж, facebook пэйж болон www.umnugovi.burtgel.gov.mn вэб хуудсаар дамжуулан авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сурталчилсан.<br>Нийт 1 удаа. | 30% |
| **Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.** | | | | | | | |
| 7.1. | Байгууллагын 2024 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | - | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100% | 100% | - ТАЗ-ын 7:4:10 сургалтад тухай бүр албан хаагчдыг бүрэн хамруулсан.<br>- 2024 оны 04 дүгээр сарын 15 ны өдөр Нийгмийн даатгалын багц хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах сургалтад хэлтсийн 5 албан хаагчийг хамруулсан<br>- 2024 оны 04 дүгээр сарын 29 ны өдөр Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>- 2024 оны 05 дугаар сарын 14 ны өдөр Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос зохион байгуулсан сургалтад хэлтсийн 14 албан хаагчийг хамруулсан.<br>- 2024 оны 05 дугаар сарын 15 ны өдөр Тагнуулын ерөнхий газрын Өмнөговь аймаг дахь газраас зохион байгуулсан Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх танхимын сургалтад хэлтсийн 11 албан хаагчийг хамруулсан.<br>- Улсын бүртгэлийн хэлтсийн нийт 15 албан хаагчид 2024 оны 03 дугаар сарын 01 ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15 ны хооронд Улсын тэргүүний 2 дугаар сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Б. Бямбацэцэгээр 7 хоног бүрийн 2, 3 дахь өдөр | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | монгол бичгийн анхан болон дунд шатны хичээлийг заалгаж судалсан.<br>- 2024 оны 05 дугаар сарын 24-нд Bestтөвтэй хамтран иргэдэд "Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт" сэдвээр сургалт зохион байгуулсан. | |
| 7.2. | Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээг нэмэгдүүлэх. | - | Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийн хичээлийг судалж, шалгалт өгсөн албан хаагчийн тоо | 28 | 30 | 2024 оны 05 дугаар сарын байдлаар хүний нөөц, сургалтын нэгдсэн систем дэх сургалтыг цахимаар бүрэн судлаж 24 албан хаагч шалгалт өгсөн. Мөн Албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн УБЕГ-ын Тамгын газрын хүний нөөцийн мэргэжилтэнд заасан хугацаанд бүрэн хүргүүлсэн. | 80% |
| 7.3. | Бусад Улсын бүртгэлийн хэлтэстэй харилцан туршлага солилцох. | | Харилцан туршлага солилцох алба хаагчдын тоо | 15 | 20 | Бусад Улсын бүртгэлийн хэлтэстэй харилцан туршлага солилцох ажлын төлөвлөгөөт хугацаа 3,4 дүгээр улиралд хэрэгжилнэ. | 50% |
| 7.4 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийг хариуцлагын даатгалд даатгуулах. | - | Даатгалд хамруулсан улсын бүртгэгчийн тоо | 0 | 3 | 2024 оны 04 сарын 25 ны өдөр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийг хариуцлагын даатгалд даатгуулах 7 улсын бүртгэгчийн судалгааг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. | 50% |
| **ЗОРИЛГО. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "НУТГИЙН ХИШИГ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 8. Төрийн үйлчилгээг хүний эрхийг дээдлэх, иргэдийн оролцоог хангаж ёс зүйтэй, хариуцлагатай, шуурхай, хүртээмжтэй, ил тод хүргэнэ.** | | | | | | | |
| 8.1. | "Нутгийн дэм" хөтөлбөрт алба хаагчдыг бүрэн хамруулах. | Орон нутгийн санхүүжилт | "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоо | 28 | 30 | Улсын бүртгэлийн хэлтсийн 28 албан хаагч "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж 57 677 091 төгрөгний дэмжлэг авч олгосон. | 50% |
| 8.2. | Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх асуудлыг журмын дагуу шийдвэрлүүлэх | Аймгийн ЗДТГазрын санхүүжилт | Ипотекийн зээлд дэмжлэг авсан албан хаагчдын тоо | 3 | 4 | Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн хишиг" хөтөлбөрийн хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч А.Цэцэгжаргал нар тус бүр 5 сая төгрөгийн дэмжлэг авсан. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.3. | Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороо | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан хаагчдын тоо | 14 | 20 | 2024 оны 05 дугаар сарын 06, 10-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн хэлтсийн 20 албан хаагчыг 2 ээлжээр Улаанбаатар хотод Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багц шинжилгээ, үзлэг”-т бүрэн хамруулсан. | 100% |
| 8.4. | Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг нэмэгдүүлэх | Орон нутгийн санхүүжилт | Шинэчлэгдсэн тоног төхөөрөмж, эд хөрөнгийн тоо | 29 | 40 | Өмнөговь аймгийн Худалдан авах ажиллагааны авах ажил лагааны газраас 2024 оны 04 дүгээр сарын 05 ны Өмнөговь аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтэст төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх 150,000,000 төгрөгний тендэр зарласан. Тендир шалгаруулалтын дугаар ӨМАХААГ/20240101710 | 50% |
| 8.5. | Аймгийн ИТХурлын 2022 оны 12 дугаар сарын 01 ны өдрийн 9/9 дүгээр тогтоолоор Даланзадгад суманд шинээр байгуулагдсан 9, 10 дугаар багийн иргэдийн бичиг баримтыг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх | Аймгийн ЗДТГазрын нөөц хөрөнгө | Даланзадгад суманд шинээр байгуулагдсан 9, 10 дугаар багийн иргэдийн бичиг баримтыг шинэчилсэн тоо | 2133 | 2500 | Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөр, “Явуулын оффис”-оор 2024 оны 1-4 дүгээр саруудад Даланзадгад суманд шинээр байгуулагдсан “Чандмань” 9 дүгээр баг, “Начин” 10 дугаар багийн иргэдэд нийт 12 удаа улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээг үзүүлж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 879, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 542, хуулийн этгээдийн чиглэлээр 45 иргэний бичиг баримтыг сольж олгосон. | 50% |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх ажил | Эхлэх, дуусах огноо |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |

| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАГЦ ХУУЛЬ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Удирдлагын академын Эрхэлсэн түшмэлийн багц сургалтанд хамрагдаж, 8 кредит цагийн хичээлийг судлах | Эрхэлсэн түшмэлийн багц сургалтанд бүрэн сууж, шалгалт өгч, төгссөн байна. | Удирдлагын академын Эрхэлсэн түшмэлийн багц сургалтанд хамрагдаж, 9 кредит цагийн хичээлийг судлаж, амжилттай төгссөн. | 2024-2025 |
| 2 | Төрийн албаны зөвлөлийн сургалт болон бусад мэргэжил арга зүйн сургалтад хамрагдах | Мэргэжил, мэдлэг арга зүйн ур чадвар нэмэгдсэн байна. | 2024 оны эхний 5 сарын байдлаар Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтанд 12 удаа цахимаар оролцож, мэдээлэл авч, ажлын ур чадвараа нэмэгдүүлсэн. | 2024-2025 |
| 3 | Хувь хүний хөгжил, манлайллын чиглэлээр судлах | Өөрийн удирдан зохион байгуулах, илтгэх ур чадварыг нэмэгдүүлсэн байна. | Хувь хүний хөгжил, илтгэх ур чадвар, манлайлалын чиглэлийн ном уншиж, судалсан. | 2024-2025 |
| 4 | Улсын бүртгэлийн байгууллагын Хүний нөөцийн нэгдсэн системд байршуулсан хичээл, чиглэл, арга зүйн зөвлөмжүүдийг судлах | Хичээлүүдийг судалж, шалгалт өгч, мэдлэг нэмэгдсэн байна. | Хичээлүүдийг бие даан судалж, шалгалтыг хугацаанд нь өгсөн. | 2024-2025 |

Тайланг үнэлсэн: **Төсвийн төвлөрүүлэн захирагч**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .................................. /Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал ) (гарын үсэг)

....................................

(огноо)

Тайлагнасан: **Төсвийн шууд захирагч**

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА .................................. /Ч.ЭНХМӨНХ/

(албан тушаал ) (гарын үсэг)

9138706
ГСТ7460 1123020005

2024.05.31

(огноо)